



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05 дугаар сарын 28 өдөр

Дугаар 54

Хэрлэн сум

LIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 54 дүгээр хуралдаан 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 77,8 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Дорнод аймгийн хэмжээнд дархлаажуулалтын ажлын явцын талаар мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар

2.Баян-Уул суманд үүссэн нөхцөл байдлын талаар танилцуулах,

Эрүүл мэндийн газар

3.Хэрлэн сум болон алслагдсан сумын хяналтын цэгийн үйл ажиллагааг сунгах эсэх талаар хэлэлцэх,

Цагдаагийн газар

4.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

5.Алдарт эхийн одонг гардуулах эсэх талаар хэлэлцэх,

Аймгийн Засаг даргын Тамгын газар

6.Ачаа тээврийн хяналтыг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар хэлэлцэх,

Авто тээврийн төв

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Шуурхай штабын гишүүдэд:

1.1.Шуурхай штабын ерөнхий зохицуулагчаар үүрэг гүйцэтгэж буй гишүүд Баян-Уул сумаас гарах, орох хөдөлгөөний талаар аймгийн Шуурхай штабын хурал бүрт танилцуулж шийдвэрлүүлэх,

1.2.Гэрийн тусгаарлалтыг оновчтой зохион байгуулах тухай гишүүн бүр нэг саналыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад цахимаар танилцуулах,

On /М.Бадамсүрэн
Hand /Д.Баттулга

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.3. 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийн хооронд Баян-Уул сумаас Хэрлэн суманд ирсэн иргэдийн судалгааг гаргах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

1.4. Дархлаажуулалтын ажлыг Баян-Уул суманд үргэлжлүүлэх эсэх талаар саналыг аймгийн Шуурхай штабын хуралд танилцуулах,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
хурандаа Б.Бямба,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.5. Баян-Уул суманд гэрийн тусгаарлалтад байсан иргэн дэглэм зөрчсөнтэй холбогдон гарсан зардлыг тооцож Санхүүгийн албанд хянуулж бүрдүүлэх,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

1.6. Аймгийн Сонгуулийн хороо Баян-Уул сумын Сонгуулийн хорооноос сонгуулийг хэрхэн зохион байгуулах талаар санал авч аймгийн Шуурхай штабын хуралд танилцуулж шийдвэр гаргуулах,

Хоёр. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Хилийн болон Зэвсэгт хүчний ангийн захирагч,
Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дарга нарт:

2.1. Алслагдсан хөдөлгөөнт хяналтын цэгүүдэд Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Хилийн анги, Зэвсэгт хүчний анги, төрийн болон

/  / М.Бадамсүрэн
/  / Д.Баттулга

орон нутгийн өмчит байгууллагуудын албан хаагч нарыг 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг дуустал дайчлан ажиллуулах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

2.2.Алслагдсан хөдөлгөөнт хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх албан хаагчдын хуваарийг гарган аймгийн Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулж батлуулах,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

2.3.Алслагдсан хөдөлгөөн хяналтын цэгүүдийг 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг дуустал ажиллахад гарах зардлыг тооцож аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр-д:

2.4.Дорнод аймгийн ачаа тээврийн хяналтыг 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг дуустал үргэлжлүүлэн зохион байгуулах,

Гурав.АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

3.1.Говьсүмбэр аймгийн Онцгой комиссоос аймгийн Шуурхай штабт ирүүлсэн “Дорнод аймагт нэвтрэх тухай” хүсэлтийн дагуу Говьсүмбэр аймгийн Шүүхийн газартай холбогдож зорчих иргэдийн талаар судалж хариуг мэдэгдэх,



Дөрөв.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
гишүүн Ш.Ёл,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан,
сум, багийн Засаг дарга, Онцгой комиссын нарт:

4.1.Алдарт эхийн одонг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн Ш.Ёл ахлан Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, сум, багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй байгуулах,

/  /М.Бадамсүрэн
/  / Д.Баттулга

Сумын Засаг дарга, Онцгой комиссын
дарга нарт:

4.2.Хүн амын дунд халдвар бүртгэгдээгүй сумдад Алдарт эхийн одонг гардуулах үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэм баримтлан, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүйгээр сум, багийн түвшинд зохион байгуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  . Д.БАТТУЛГА

